


Унадаг дугуйгаар зорчихдоо замын хөдөлгөөний дүрмээ мөрдөж хөдөлгөөнд соёлтой оролцоно уу!



Авто машин зорчих замыг = 「авто машины зам」, Явган хүн зорчих замыг = 「явган хүний зам」 гэнэ. Унадаг дугуй нь тээврийн хэрэгслийн төрөлд орно.

Унадаг дугуй авто машины замын зүүн гар талаар урсгал дагуу зорчино. Баруун гар талаар урсгал сөрж зорчиж болохгүй.



Зөвхөн дараах гурван тохиолдолд дугуйтай хүн явган хүний замаар зорчиж болно.

- ① Дугуйтай хүн явган хүний замаар зорчиж болно гэсэн тэмдэгтэй үед
- ② Зорчиж буй хүн 12-оос доош, 70-аас дээш настай байх үед
- ③ Машин зам хааж зогссон болон засварын ажлын улмаас тухайн замаар зорчиход аюултай үед

※ Явган хүний замаар зорчихдоо явган хүнд саад болж болохгүй.



Замын хөдөлгөөний самбар (тухайн замаар зорчих журам) чанд баримтална уу.




Гэрлэн дохио

	Улаан Зогс	Явж болохгүй
	Ногоон Зорчих	Баруун зүүн талаа нягтлах
	Шар Анхаар	Зорчиж болохгүй

- Түр зогсох**
Түр зогсож орчны аюулгүй байдлыг хянах
- Хурд сааруулах**
Хурд сааруулж зогсох боломжтой явах
- Явган хүн • Дугуйн зам**
Явган болон дугуйтай хүн зорчино
- Явган хүний зам**
Зөвхөн явган хүн зорчино.

Дараах хориотой зүйлсийг хийж болохгүй!

- Өөр дугуйтай хүнтэй зэрэгцэж явж болохгүй.
- Сундалдаж явж болохгүй.
- Дугуй унахдаа чанга хөгжим сонсож болохгүй.
- Согтруулах ундаа уусны дараа дугуй унаж болохгүй.
- Дугуй унахдаа бороо болон нарны шүхэр барьж болохгүй.
- Гар утас болон ухаалаг утсаар ярьж, оролдож болохгүй.
- Харанхуй үед гэрэл асаалгүй дугуй унаж болохгүй.



Дугуйны даатгалд хамрагдана. Зайлшгүй хамрагдах үүрэгтэй.

Дугуй унаж яваад бусдад гэмтэл учруулах, амь насанд нь хохирол учруулсан тохиолдолд их хэмжээний нөхөн төлбөр төлөх болно. Даатгалд хамрагдсан эсэхээ нягтална уу.

2021 оны 4 сарын 1-нээс

Дугуй унаж байхад гарсан ослын жишээ

Дугуй унаж байхдаа явган хүнийг мөргөсөн. Явган хүн ухаан алдаж унасан ба хүнд бэртэл авсан. Дугуй унаж явсан хүн, 95.210.000 иений төлбөр төлөх болсон.



Миязаки мужийн дугуйны дүрэм мөрдөгдөж эхэллээ! Дугуйны даатгалд заавал хамрагдана.



Миязаки мужийн цахим хуудсан дахь даатгалын компанийн танилцуулга

Дугуйны засвар үйлчилгээг хийх.

Мияконожо хот Нэгдсэн бодлого төлөвлөлтийн хэлтэс Гадаад харилцааны тасаг